



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 307


Улаанбаатар хот

Эмчлэх үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25.4 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.8, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн гадаадын 2 эмнэлгийн мэргэжилтний нэр, мэргэжлийн чиглэл, зөвшөөрлийн хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтын дагуу зөвшөөрлийн гэрчилгээг тушаал гарсан өдрөөс бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081038

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 1 өдрийн
307 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД ЭМЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ГАДААДЫН 2 ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Мэргэжлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Үйл ажиллагаа эрхлэх хугацаа
1.	Тайн Нийтлинг Neetnling Tine	ӨАБНУ	"СОС Медика Монголиа" эмнэлэг	0001373	Яаралтай тусламж	Эмчлэх	1 жил
2.	Чой Ин Сонг Choi In Sung	БНСУ	"Миракл Медиа" эмнэлэг	0001374	Зүү, төөнө засал судлал	Эмчлэх	1 жил